



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2022 оны 08 сарын 09 өдөр

Дугаар А/407

Улаанбаатар хот

Төрөөс эмийн зардлыг нь хариуцан амбулаториор эмчлэх өвчний жагсаалт, эм олгох үйл ажиллагааг зохицуулах журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, 24 дүгээр зүйлийн 24.6.6, 24.6.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Төрөөс эмийн зардлыг нь хариуцан амбулаториор эмчлэх өвчний эм олгох үйл ажиллагааг зохицуулах журмыг нэгдүгээр, төрөөс эмийн зардлыг нь хариуцан амбулаториор эмчлэх өвчний жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Төрөөс эмийн зардлыг нь хариуцан амбулаториор эмчлэх өвчний эмийн санхүүжилтийг жил бүр улсын төсөвт тусган батлуулахыг Санхүү, эдийн засгийн газар /Б.Мөнхтуул/-т даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар /Л.Бямбасүрэн/, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар /Д.Нарантуяа/, бүх шатны төрийн өмчит эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /С.Төгсдэлгэр/-т үүрэг болгосугай.

САЙД



С. ЭНХБОЛД

141221912

Эрүүл мэндийн сайдын 2022 оны  
08 сарын 09-ны өдрийн 4 дугаар  
тушаалын нэгдүгээр хавсралт

Төрөөс эмийн зардлыг нь хариуцан амбулаториор эмчлэх өвчний жагсаалт,  
эм олгох үйл ажиллагааг зохицуулах журам

### **Нэг. Нийтлэг зүйл**

1.1 Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6.6, 24.6.7 дахь заалтад тусгагдсан өвчний үед төрөөс төлбөрийг нь хариуцан амбулаториор эм олгох үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.

1.2 Төрөөс эмийн зардлыг нь хариуцан амбулаториор эмчлэх өвчинд хэрэглэх эм (цаашид “төр хариуцах эм” гэх) олгох үйлчилгээг төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллага (төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төв, тусгай эмнэлэг, өрх\*, сум, тосгоны эрүүл мэндийн төв) үзүүлнэ.

### **Хоёр. Төр хариуцах эм иргэнд олгох**

2.1. Энэхүү журмын хоёрдугаар хавсралтаар батлагдсан оношоор хяналтад шинээр орж байгаа өвчтөний оношийг баталгаажуулж, олгох эмийг аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төвд Эмнэлэг хяналтын комисс, төв болон төрөлжсөн мэргэшлийн эмнэлэгт Эмч нарын зөвлөгөөний хурлаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

2.2. Хяналтын эмч өвчний онош, эмнэлзүйд үндэслэн Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолоор батлагдсан эмийн жагсаалтаас сонгон, эмийг ерөнхий нэршлээр эмийн жоронд бичнэ.

2.3. ХДХВ/ДОХ-той өвчтөний хэрэглэх эмийг тухайн “өвчтөний код” бүхий эмийн жороор олгоно.

2.4. Хяналтад байгаа өвчтөнд олгож буй эмийн нэр төрөл, тун хэмжээнд өөрчлөлт оруулах, эмийг үргэлжлүүлэн олгох эсэх асуудлыг тухайн өвчтөний хяналтын эмч хариуцан хэрэгжүүлнэ.

2.5. Эмийг олгохдоо өвчтөнийг цахим системд бүртгэн тухайн эмнэлэг өөрийн эмийн сангаар дамжуулан сар бүр олгоно. Онцгой тохиолдолд зарим өвчтөнд (байгалийн гамшигт өртөх, гадаадад эмчлэгдэх гэх мэт) Эмнэлэг хяналтын комисс, Эмч нарын зөвлөгөөний шийдвэрээр 3 сар хүртэлх хугацаанд хэрэглэх эмийг олгож болно.

2.6. Сүрьеэгийн эмийг аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн төв, өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөр дамжуулан олгож болно.

2.7. Хяналтад байгаа өвчтөн шилжилт хөдөлгөөн хийх тохиолдолд холбогдох эрүүл мэндийн байгууллагууд мэдээллийг цахимаар солилцон эмчилгээ, хяналтыг үргэлжлүүлж эмийг тасралтгүй олгох үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

### **Гурав. Төр хариуцах эм олгох үйл ажиллагаанд оролцогч талуудын үүрэг**

3.1. Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын үүрэг:

3.1.1. Төр хариуцах эмийн жагсаалтыг Монгол Улсад бүртгэлтэй, олон улсын эмнэлзүйн удирдамжид үндэслэн боловсруулж, батлуулах;

3.1.2. Төр хариуцах эмийн санхүүжилтэд шаардагдах хөрөнгийн хэмжээг эмийн хэрэгцээ шаардлага, эмийн нэгдсэн худалдан авалтын үнэ, эрүүл мэндийн байгууллагад олгосон өмнөх жилүүдийн гүйцэтгэлд үндэслэн тооцон, төлөвлөх;

3.1.3. Төр хариуцах эмийн санхүүжилтийн хэмжээг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас Эрүүл мэндийн байгууллагатай хийх тусламж, үйлчилгээний гэрээний хавсралтад тусган баталж, гүйцэтгэлээр санхүүжүүлэх;

3.1.4. Төр хариуцах эмийн жагсаалтад орсон эмийн онцлог, нийлүүлэлтийн нөхцөлөөс хамааруулан тухайн эмийн санхүүжилтийг эрүүл мэндийн байгууллагад сар, улирлаар урьдчилан олгож болох бөгөөд холбогдох зохицуулалтыг эрүүл мэндийн байгууллага, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар хоорондын гэрээнд тусгайлан заах;

3.1.5. Эм олгох үйл ажиллагааг эрүүл мэндийн даатгалын цахим системд оруулж нэхэмжлэлийн хяналтын үйл ажиллагааг цахимжуулан статистик, тайлан мэдээллийг тухай бүрт гаргах;

3.1.6. Эрүүл мэндийн даатгалын цахим програмд төр хариуцах эм олгох үйл ажиллагааны цахим хөгжүүлэлтийг тогтмол хийх;

3.1.6. Олон улсын төсөл, хөтөлбөрийн хүрээнд нийлүүлэгдэж буй төлбөрийг нь төр хариуцах өвчний эмчилгээний эмийн төсвийг улсын төсөвт үе шаттайгаар шилжүүлэх санал боловсруулж холбогдох байгууллагуудад хүргүүлэх.

3.2. Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын үүрэг:

3.2.1. Төр хариуцах эмийн хангамж, нөөц бүрдүүлэлтэд тогтмол хяналт тавьж тухай бүрт зохицуулалт хийн тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах;

3.2.2. Төр хариуцах эмийн үнэ, хэрэгцээ, хэрэглээний зах зээлийн тандалт судалгаа тогтмол хийх;

3.2.3. Олон улсын төсөл, хөтөлбөрийн хүрээнд авч байгаа төр хариуцах эмийн хэрэглээ, хадгалалт, чанарт хяналт тавих, зохицуулалт хийх;

3.2.4. Ерөнхий гэрээгээр худалдан авах төр

хариуцах эмийн үнэ, хэрэгцээ, техникийн шаардлагыг тодорхойлж, захиалгыг Төрийн худалдан авах ажиллагааны газарт цаг хугацаанд нь хүргүүлэх;

3.2.5. Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эмийн үйлдвэр, ханган нийлүүлэгчээс шууд худалдан авах эмийн нэр төрлийг тодорхойлох, хэрэгцээг тооцох, техникийн шаардлагыг боловсруулах, эм хангамжийн тасралтгүй байдлыг хангах үйл ажиллагааг хэрэгжүүлэх, зохицуулах;

3.2.6. Төр хариуцах эмийн нөөц, зарцуулалтын мэдээ, тайланг улирал бүр, шаардлагатай тохиолдолд тухай бүрт Эрүүл мэндийн яам болон бусад холбогдох байгууллагад хүргүүлж, мэдээллээр хангаж ажиллах;

3.2.7. Төр хариуцах эмийн чанар, аюулгүй байдалд тандалт судалгаа хийх, жор бичилтэд хяналт тавих;

3.3. Бүх шатны төрийн өмчит эрүүл мэндийн байгууллагын үүрэг:

3.3.1. Эрүүл мэндийн даатгалын цахим програмд төр хариуцах эм олгох үйл ажиллагааг нэвтрүүлэх;

3.3.2. Төр хариуцах эмийн нөөцийн бэлэн байдлыг хангах;

3.3.3. Төр хариуцах эмийн чанар, аюулгүй байдал, хадгалалтын горим, хүчинтэй хугацаа зэрэгт тогтмол хяналт тавих;

3.3.4. Хяналтын эмчээс төр хариуцах эм олгож байгаа үйл ажиллагаанд тогтмол хяналт тавих;

3.3.5. Ерөнхий гэрээгээр худалдан авах эмийг "Төрийн худалдан авах ажиллагааны цахим дэлгүүр"-ээс худалдан авах;

3.3.6. ХДХВ/ДОХ, Сүрьеэгийн тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах


3.3.6.1. Халдварт өвчин судлалын үндэсний төв нь үндэсний хэмжээнд сүрьеэгийн тусламж, үйлчилгээнд шаардагдах эмийн нөөцийг Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас зөвлөмж болгосны дагуу бүрдүүлэх, төсвийн тооцооллыг жил бүр хийх, бусад эрүүл мэндийн байгууллагыг эмээр хангах, эмийн хадгалалт, хамгаалалтад тогтмол хяналт тавих;

3.3.6.2. Шаардлагатай тохиолдолд ХДХВ/ДОХ, сүрьеэгийн эм болон дархлал дарангуйлах эмийг гадаадын зээл тусламж, гэрээгээр худалдан авах үйл ажиллагааг Халдварт өвчин судлалын үндэсний төв зохион байгуулж болох ба энэ тохиолдолд Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газраас чиглэл авч, хамтран ажиллах.

#### **Дөрөв. Бусад**

4.1. Энэхүү журмыг зөрчсөн тохиолдолд бусад хууль, журамд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Эрүүл мэндийн сайдын 2022 оны  
08 сарын 09-ны өдрийн 4 дугаар  
тушаалын хоёрдугаар хавсралт



Төрөөс эмийн зардлыг нь хариуцан амбулаториор эмчлэх  
өвчний жагсаалт

№		Өвчний код	Шалгуур	Хасах шалгуур
1	Сэтгэц, зан үйлийн эмгэг	F00	Хэсэгчилсэн болон бүтэн тэнэгрэлд орж бусдын асрамж шаардлагатай болсноос хойш Дахилт ойр ойрхон болсноос хойш Дэмийрлийн шинж тогтвортой илэрснээс хойш Зан төрхийн болон танин мэдэхүйн, сэтгэхүй, хэл ярианы өөрчлөлттэй болсноос хойш Зан төрхийн өөрчлөлттэй, ухамсарт ухаан бүрийтэн балартал, солиорол бүхий уналт таталттай болсноос хойш Архины шалтгаант солиорол /паранойд/ хоорондоо богино хугацааны давтамжтай эсвэл тэнэгрэл илэрснээс хойш Опиоидын шалтгаант солиорол /паранойд/ хоорондоо богино хугацааны давтамжтай эсвэл тэнэгрэл илэрснээс хойш Олон төрлийн сэтгэц идэвхит бодисын шалтгаант солиорол /паранойд/ хоорондоо богино хугацааны давтамжтай эсвэл тэнэгрэл илэрсэн бол Солиорлын болон негатив шинжүүд тогтвортой илэрч, засрал сайжралд ордоггүй болсоноос хойш Шизоаффектив эмгэгийн солиорол бүхий сэтгэл хөөрөх шинжүүд дахин давтагдан болон тасралтгүй илэрснээс хойш Шизоаффектив эмгэгийн солиорол бүхий сэтгэл гутрах шинжүүд дахин давтагдан болон тасралтгүй илэрснээс хойш	Насан туршид
		F01		
		F02.8		
		F06.1		
		F06.2		
		F07.0		
		F07.8		
		F10		
		F11		
		F19		
		F20		
		F20.1		
		F20.2		
		F20.3		
		F20.4		
		F20.5		
		F20.6		
F20.8				
F21				
F22				
F25.0				
F25.1				

		F25.2	Шизоаффектив эмгэгийн солиорол бүхий сэтгэл хөөрөх, гутрах шинжүүд дахин давтагдан болон тасралтгүй илэрснээс хойш	
		F31.2	Солиорлын шинж тэмдэгтэй сэтгэл хөөрөх тохиолдол бүхий хоёр туйлт сэтгэл цочирдох шинж 6 сараас доош хугацаанд дахилт өгсөнөөс хойш	
		F31.5	Солиорлын шинж тэмдэгтэй сэтгэл гутрах тохиолдол бүхий хоёр туйлт сэтгэл цочирдох шинж 6 сараас доош хугацаанд дахилт өгснөөс хойш	
		F31.6	Сэтгэл цочирдлын хоёр туйлт (сэтгэл хөөрөл, сэтгэл гутрал) шинж 6 сараас доош хугацаанд дахилт өгснөөс хойш	
		F33.1	Сэтгэл гутрах дахилтат шинж 6 сараас доош хугацаанд дахилт өгснөөс хойш	
		F33.2	Солиорлын шинжгүй хүнд хэлбэрийн сэтгэл гутрах шинж 6 сараас доош хугацаанд дахилт өгснөөс хойш	
		F33.3	Солиорлын шинжтэй хүнд хэлбэрийн сэтгэл гутрах дахилтат шинж 6 сараас доош хугацаанд дахилт өгснөөс хойш	
		F70	Зан төрхийн өөрчлөлт эхэлснээс хойш	
		F71	Зан төрхийн өөрчлөлт эхэлснээс хойш	
		F72	Зан төрхийн өөрчлөлт эхэлснээс хойш	
		F84	Нийгмийн харилцаанд оролцох чадвар сул болсоноос хойш	
2	Уналт таталт /эпилепси/	G40.0- G40.9 G40.5	• Хүүхэд	Насан туршид
3	Нүдний даралт ихсэх өвчин	H40-H42	• Даамжирсан үе шат	Эзэнэгшилд орох хүртэл
4	Эрхтэн шилжүүлсний дараах байдал	K74 K75,4 C22.0 Q44.2 I82.0 Z94.4 N18.0 E11 M32 I42.9 Z94.0	• Элэг, бөөр шилжүүлэн суулгасны дараах • Дархлаа дарангуйлах эмчилгээ зайлшгүй шаардлагатай тохиолдол	Насан туршид
5	ХДХВ/ДОХ	B20 B21 B22 B23	Бүх тохиолдолд	Насан туршид

		B24		
		Z20.6	Халдварт өртсөн тохиолдолд	Өртсөн даруй 72 цагийн дотор нийт 28 хоног
6	Чихрийн шижин	E10	Хүүхэд	Насан туршид
		E11		
7	Чихрийн бус шижин	E23.02	Бүх тохиолдолд	Насан туршид
8	Сүрьеэ	A15-A16	Уушгины сүрьеэ /эмэнд мэдрэг/	Оношлогдсоноос хойш 6-9 сар
			Уушгины сүрьеэ /дахилт, давтан, нэг болон цөөн эмэнд тэсвэртэй/	Оношлогдсоноос хойш 9 -12 сар
			Уушгины сүрьеэ /олон эмэнд тэсвэртэй дахилт, давтан/	Оношлогдсоноос хойш 9-12 сар
			Уушгины бус сүрьеэ /олон эмэнд тэсвэртэй дахилт, давтан/	Оношлогдсоноос хойш 18-20 сар
		A17-A19	Уушгины бус сүрьеэ /эмэнд мэдрэг/	Оношлогдсоноос хойш 6- 9 сар
			Уушгины бус сүрьеэ /дахилт, давтан, нэг болон цөөн эмэнд тэсвэртэй/	Оношлогдсоноос хойш 9-12 сар
			Уушгины сүрьеэ болон Уушгины бус сүрьеэ /маш олон эмэнд тэсвэртэй сүрьеэ/	Оношлогдсоноос хойш 6-20 сар
Z22.7	Бүх тохиолдолд	Оношлогдсоноос хойш 1-6 сар		
9	Паркинсоны өвчин	G20	Бүх тохиолдолд	
10	Гемофили	D66	Бүх тохиолдолд	Насан туршид
11	Бамбай булчирхайн дутмагшил	E00	Бүх тохиолдолд	Насан туршид
		E03		
12	Өнчин тархины шалтгаант өсөлтийн хоцрогдол /нанизм/	E23 E23.6	Бүх тохиолдолд	Насан хүрэгчдийн дундаж өндөрт хүртэл
13	Удамшлын шалтгаант өсөлтийн хоцрогдол /синдром Тернер/	Q96		
14	Ахондроплази	Q77.4		
15	Өөр бүлэгт ангилаагүй одой өсөлт	E34,3		
16	Өөр бүлэгт ангилсан дотоод шүүрлийн бусад эмгэг /бөөрний архаг дутагдлын шалтгаант өсөлтийн хоцрогдол, умай доторх өсөлтийн дааврын дутагдал, өнчин тархины хавдрын мэс заслын дараах өсөлтийн хоцрогдол, бусад дааврын дутагдал/	E35.8		
17	Миастени	G70.0- G70.9	Бүх тохиолдолд	Насан туршид

18	Хорт хавдрын /бүх төрлийн/ дөрөвдүгээр үе шат		Бүх тохиолдолд	Насан туршид
19	Булчингийн чангарал /дистони/	G24	Бүх тохиолдолд	Насан туршид
20	Тархины саажил	G80.0-80.9	Бүх тохиолдолд	Насан туршид
21	Бөөрний дээд булчирхайн холтослог давхаргын үйл хямрал	E25	<ul style="list-style-type: none"> <li>• Энгийн эрших хэлбэр</li> <li>• Давс хаях хэлбэр</li> <li>• Сонгомол бум хэлбэр</li> <li>• Хүүхэд</li> </ul>	Насан туршид
22	Тархмал хатуурал	G35	Бүх тохиолдолд	Насан туршид
23	Виллебрандын өвчин	D68.0	Бүх тохиолдолд	Насан туршид
24	Цочмог промиелоцитын лейкеми	C92.4	<ul style="list-style-type: none"> <li>• Цусны цочмог хавдар оношлогдсон даруйд</li> <li>• Хүүхэд</li> </ul>	Насан туршид
	Архаг лимфолейкеми Лимфомууд	C91.1 C81-85	<ul style="list-style-type: none"> <li>• Үүдэл эс шилжүүлэн суулгах эмчилгээ хийгдээгүй тохиолдолд</li> <li>• Хүүхэд</li> </ul>	Насан туршид
	Архаг миелопролифератив эмгэгүүд	C92.1 D45 D47	<ul style="list-style-type: none"> <li>• Үүдэл эс шилжүүлэн суулгах эмчилгээ хийгдээгүй тохиолдолд</li> <li>• Хүүхэд</li> </ul>	Насан туршид
	Түгмэл миелом болон парапротеинемийн бусад хавдрууд	C88-C90	<ul style="list-style-type: none"> <li>• Хүүхэд</li> </ul>	Насан туршид